



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн давтан аудитын тайлан

“УРСГАЛ-УС ХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ӨГӨГДСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДАВТАН АУДИТЫН ТАЙЛАН

Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт дунджаар 70.1 хувьтай байна.



Сүхбаатар сум 2017 он

Тайланг бэлтгэсэн:
Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Аудитор
Б.Эрдэнэзул

2017 оны 10 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70363036
дугаарын утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:Сэлэнгэ аймгийн
Сүхбаатар сум аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, бүрэн арилгасан уу?

- 1.1. Актыг бүрэн барагдуулсан уу?
- 1.2. Албан шаардлагын биелэлтийг хангаж, зөрчлийг таслан зогсоосон уу?

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан уу?

- 2.1 Аймгийн Засаг дарга, Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдэд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн үү?
- 2.2 Компанийн гүйцэтгэх захирал, санхүүгийн ажилтнуудад өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн үү?

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТХШС	Төрийн хяналт шалгалтын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

2016 онд хийгдсэн “Урсгал-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд давтан аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, бүрэн арилгасан уу?
- Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Аудитад Урсгал-Ус ХХК-ийн 2016 оны 9 дүгээр сараас 2017 оны 10 дугаар сар хүртэлх үйл ажиллагааг хамруулсан болно.

1.3 Аудитын арга зүй

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан Урсгал-Ус ХХК-ийн захирал, нягтлан бодогчид, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, компанийн ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийсэн бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хууль, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд болон Сангийн сайдын 2012 оны 77-р тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Б.Эрдэнэзул 2017 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны хооронд хийж гүйцэтгэв.

1.5 Ерөнхий мэдээлэл

Сэлэнгэ аймгийн нийтийн аж ахуйн Урсгал-Ус ХХК нь 1931 онд “Нийтийн үйлчилгээний товчоо, хот тохижилт” нэртэйгээр анх байгуулагдаж, 1997 онд “Урсгал” улсын үйлдвэрийн газартай нэгтгэн Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болгон зохион байгуулсан бол 2005 онд аймгийн ИТХТ-ийн 78 дугаар тогтоолоор “Урсгал-Ус ХХК” болгон өөрчилсөн байна.

Тус компани нь Захиргаа аж ахуй, Борлуулалтын, Цэвэр ус хангамжийн, Ариутгах татуургын, Нийтлэг үйлчилгээний, Авто гражийн зэрэг 5 албатайгаар, 106 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Урсгал-ус ХХК-ийн гүйцэтгэх захирлыг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэл М.Батболд гүйцэтгэж байгаад аймгийн Засаг даргын 2017 оны Б/21 дүгээр захирамжаар чөлөөлөгдсөн бөгөөд өнөөг хүртэл аймгийн Засаг даргын 2017 оны Б/22 дугаар тушаалаар томилогдсон А.Алтансүх гүйцэтгэж байна.

Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдөр хүртэл А.Алтансүх гүйцэтгэж байгаад компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны 51 дүгээр тушаалаар Г.Сэржмядагыг томилон ажиллуулж байна.

2016 онд хийж гүйцэтгэсэн “Урсгал-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нийт **1,013,820.9** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч **35,787.1** мянган төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, **583,762.5** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **394,271.3** мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Бүлэг 1

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, бүрэн арилгасан уу?

Өглөг, авлагын үлдэгдлийг бүрэн тооцоо нийлж баталгаажуулаагүй, ажиллагсадтай холбоотой тооцоог хааж дуусгаагүй, хандив олгосон, авто машины эзэмшлийг шилжүүлээгүй зэрэг зөрчил арилаагүй байна.

1.1 Тавигдсан актын 71.0 хувийг барагдуулсан байна.

Урсгал-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн гүйцэтгэлийн аудитаар насжилт ихтэй 35,787.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулуулах СЭЛ-01/03-ГА дугаартай төлбөрийн акт бичигдсэн.

Үүнээс 2013 оноос үүссэн Монхово ХХК-тай холбоотой 25,392.5 мянган төгрөгийн авлагыг тус бүр нь 7,500.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг дизель станц, 10,400.0 мянган төгрөгийн үнэтэй ЭЦВ насос авч бүрэн барагдуулсан байна.

Харин 3 компанитай холбоотой, 2003 оноос үүссэн насжилт ихтэй нийт 10,394.6 мянган төгрөгийн авлагыг /Орхон импекс ХХК-ийн 6,791.8 мянган төгрөг, Жавхлант Эрдэнэ ХХК-ийн 1,418.6 мянган төгрөг, Ертөнцийн цамхаг ХХК-ийн 2,184.2 мянган төгрөг/ барагдуулахаар Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2017 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 221 дугаар албан бичгээр хандахад нэмэлт мэдээлэл шаардсан бөгөөд үүнийг бүрдүүлэхээр холбогдох байгууллагуудад хандсан байна.

1.2 Албан шаардлагын биелэлтийг 71.6 хувьтай хангаж ажилласан бөгөөд хандив олгох, авто машины эзэмшлийг шилжүүлэх, өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан бодитой болгох, ажиллагсадтай холбоотой үүссэн тооцоог цэгцлэх зэрэг зөрчлийг арилгаагүй байна.

“Урсгал-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар илэрсэн 11 төрлийн 583,762.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар СЭЛ-01/26-ГА, СЭЛ-02/27-ГА, СЭЛ-03/28-ГА, СЭЛ-04/29-ГА, СЭЛ-05/30-ГА дугаартай 5 албан шаардлага хүргүүлсэн.

Үүнээс 6 төрлийн 157,976.5 мянган төгрөгийн зөрчлийг бүрэн арилгаж, 3 төрлийн 395,286.0 мянган төгрөгийн зөрчлийг дутуу, 2 төрлийн 30,500.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгаагүй, давтан гаргасан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

№	Албан шаардлагаар таслан зогсоох алдааны утга	Дүн /мян.төг/	Хэрэ гжил т /%/	Тайлбар
1	Хандив олгосон	500.0	0	Тайлант хугацаанд Нийтийн аж ахуйн үйлчилгээний алба, Сүхбаатар сум үүсэж хөгжсөний ойн арга хэмжээнд нийт 2,000.0 мянган төгрөгийн хандив олгосон.
2	Тус компанид бүртгэлтэй өрмийн авто машин нь улсын бүртгэлд хувь хүний эзэмшилд бүртгэлтэй.	30,000.0	0	Байгууллагын өмчлөлд шилжүүлээгүй байна.
3	2015 оны жилийн эцсээр авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	Авлага 140,775.7 Өглөг 66,362.7	27.1	2016 оны жилийн эцсийн байдлаар нийт авлагын журналд бүртгэлтэй 476, өглөгийн журналд бүртгэлтэй 76 байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулахаас 150 байгууллагатай тооцоо нийлсэн байна. Мөн 83 байгууллагатай тооцоо нийлсэн акт нь өглөг, авлагын журналын үлдэгдэлээс зөрүүтэй байна.
4	Өөрийн компанийн ажиллагсадтай үүссэн дараа тооцоог тухай бүр хааж барагдуулаагүй, бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа зарцуулсан ч авлагаар тусган тайлант үеийн зардлыг дутуу илэрхийлсэн	58,913.2	65.6	Залруулахаар ажиллаж байгаа ч 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 38 ажилтантай холбоотой 20,234.5 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. /барагдуулсан нь 38,678,7/
5	Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөөгүй	129,234.4	95.0	Тайлант хугацаанд 10.0 саяас дээш үнийн бүхий шатахуун, экскаватор засвар, харуул хамгаалалтын албыг сонгох зэрэг худалдан авах ажиллагаанд харьцуулалтын журам мөрдсөн байна. Хэдийгээр ажлын хэсэг томилж, хурлын протокол хөтөлсөн ч ажлын хэсгээс даргадаа зөвлөмж хүргүүлээгүй, оролцсон байгууллагуудынхаа талаарх мэдээллийг баримтжуулан аваагүй, үнэлгээний хуудас бөглөөгүй байна. /Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан боловч баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй байна./

6	Удирдлагын зардлыг хэтрүүлэн зарцуулсан	6,137.9	100	Удирдлагын зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
7	Удирдамж, томилолтын үнэмлэх, холбогдох байгууллага, албан тушаалтны зөвшөөрөл, шийдвэргүйгээр санхүүгийн төлөвлөгөөнд батлагдаагүй гадаад томилолтын зардал гаргасан	21,234.6	100	Аудит хийгдсэнээс хойш гадаад томилолтын зардал гаргаагүй байна.
8	Хууль эрхийн актын үндэслэлгүйгээр байцаагч Н.Сувд-Эрдэнийн сургалтын төлбөрийг төлсөн	2,100.0	100	2016 оны 11, 12, 2017 оны 1, 2-р сарын цалингаас нийт 600.0 мянган суутгаж, 2017 оны 10-р сард 1,500.0 мянган төгрөгийг касст бэлэн тушаасан байна.
9	Аймгийн ИТХ-ын зөвшөөрөлгүйгээр 73 нэр төрлийн компьютер техник, тавилга эд хогшлыг акталж, устгасан	15,502.7	100	Хөрөнгө актлаагүй байна.
10	НӨАТ-ын тооцоог хаалгүйгээр авлага хий тусгасан	24,501.3	100	Залруулсан.
11	2011 оноос хойш орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3 удаагийн ажлыг урт хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэсэн	88,500.0	100	Залруулсан.
Нийт дүн		583,762.5	71.6	

Бүлэг 2

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан уу?

Аймгийн Засаг дарга болон ТУЗ-д өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 75.7 хувьтай, байгууллагын удирдлагад өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 61.9 хувьтай байна.

2.1 Аймгийн Засаг дарга, Компанийн ТУЗ дарга, гишүүдэд өгөгдсөн зөвлөмжийг 75.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Урсгал-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг дарга Ш.Оргилд 4, компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдэд 3 зөвлөмж хүргүүлснээс 4 зөвлөмж бүрэн, 2 зөвлөмж дутуу хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Аймгийн Засаг даргад өгсөн 3, ТУЗ-д өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан бол аймгийн Засаг даргад өгсөн “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн дагуу хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоогүй ус хангамжийн эх үүсвэрүүдэд бүс тогтоолгох саналыг аймгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн зөвлөмж огт хэрэгжээгүй байна.

Аймгийн Засаг даргад өгсөн дараах 3 зөвлөмж хэрэгжсэн байна. Үүнд:

- **Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасны дагуу Урсгал-Ус ХХК-ийн захиралтай жил бүр гэрээ байгуулж, дүгнэж байх.**

Аймгийн Засаг дарга Ш.Оргил тус компанийн гүйцэтгэх захиралтай 2017 оны үр дүнгийн гэрээг 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаатай байгуулсан байна.

Тус гэрээгээр зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2 талын эрх, үүрэг, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин, орон нутгийн өмчийн газрын эрх, эд хөрөнгийн хариуцлага, гэрээний биелэлтийг дүгнэх журам, хугацааг нарийн тодорхой зааж өгсөн байна.

- ***Зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлуудыг судалж, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.***

Сүхбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, техник технологи, инженерийн шугам сүлжээний өргөтгөлийн 4,030,217.8 мянган төгрөгийн ажлыг шийдвэрлүүлэхээр компанийн гүйцэтгэх захирлын 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 338 дугаар албан бичгээр аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэст, 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 396 дугаар албан бичгээр Барилга хот байгуулалтын яаманд тус тус хандсан байна.

Урсгал-Ус ХХК нь өөрийн хөрөнгөөр төв цэвэрлэх байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажилд 39,100.0 мянган төгрөгийг, худаг засвар, шинэчлэлтийн ажилд 20,400.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийж гүйцэтгэсэн байна.

Төв цэвэрлэх байгууламжид шинээр хаалт барих, цахилгаан халаагуур суурилуулах, гадна гэрэлтүүлгийг шинэчилэх, өрөө тасалгаанд их засвар хийснээс гадна ШУТИС-ийн багш, доктор Ц.Цацралтай гэрээ байгуулан бохир усыг технологийн горимын дагуу шүүж, цэвэршүүлэх, шавьж бактерийн зохистой тохируулга үйлчилгээг хийлгэсэн байна. Үүний дүнд 2017 оны 09 дүгээр сарын шинжилгээний дүнгээр 84 хувийн цэвэршилттэй гарсан байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын санаачлагаар ухаалаг худаг төсөл хэрэгжиж хүн ам төвлөрсөн 5 багт 3 худаг шинээр барин, 3 худгийг засварлаж, ухаалаг худгийн тоног төхөөрөмжийг суурилуулсан бөгөөд энэ нь усны алдагдлыг багасгах, ард иргэдэд 24 цагийн туршид ус түгээх үйлчилгээг нэвтрүүлж байна.

- ***Урсгал-Ус ХХК-ийн бүтэц зохион байгуулалт оновчтой эсэх асуудлыг мэргэжлийн байгууллагад хандах болон мэргэжлийн комисс ажиллуулан дүгнэлт гаргуулж, зохих арга хэмжээ авах.***

Тус компанийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-аас 2016 оны 11 дүгээр сар, 2017 оны 4-р сард 3-9 чиглэлээр */батлагдсан орон тооны дагуу ажилтнуудыг ажиллуулж байгаа эсэх, аймгийн Засаг дарга болон Аудитын газраас өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг сайжруулсан эсэх гэх мэт/* шалгалт хийж, дүгнэлт гарган хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ажил сайжруулах тухай албан даалгавар өгсөн байна.

ТУЗ-д өгсөн “**ТУЗ-ийн үйл ажиллагааг үр нөлөөтэй, үр ашигтай болгох, ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үндэслэн цалин хөлс авдаг нөхцөлийг судалж нэвтрүүлэх.**” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Харин Урсгал-Ус ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд өгсөн дараах 2 зөвлөмж дутуу болон хэрэгжих шатандаа байна. Үүнд:

Зөвлөмж	Хэрэгжилт %	Хэрэгжилтийн байдал
Стратеги төлөвлөгөө болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, мөрдүүлэх, жил бүр гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж байх. Үйл ажиллагааг сайжруулах, өр авлага бууруулах талаар тооцоо судалгаа гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих.	80	Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 10 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан ТУЗ нь 2017.03.06-д хуралдаж 8 асуудлыг хэлэлцэн 5 тогтоол гаргаж, орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, авлага барагдуулах талаар 1 зөвлөмж гаргасан байна. Гэвч 2017 оны 10 сарын байдлаар өгсөн зөвлөмжийг хэлэлцэж, хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.
Урсгал-Ус ХХК-ийн дүрэм болон аймгийн ИТХ-ын 2013 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан журмыг мөрдөж ажиллах.	50	ТУЗ нь тус журмын дараах заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үүнд: журмын 2.2 “ТУЗ-ийн ээлжит хурлыг улирал бүр хуралдуулна. ...”, 3.3 “ТУЗ нь жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллана.”, 3.5 “Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн шийдвэрийн биелэлтийг улирал бүр гаргаж, ТУЗ-ийн хуралд танилцуулж байна.”, 3.7 “ТУЗ нь батлагдсан зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулах бөгөөд тайланг нарийн бичгийн дарга хагас, бүтэн жилээр гарган ТУЗ-ийн хуралд танилцуулж байна.”, 3.8 “ТУЗ нь гишүүдэд тодорхой хариуцах ажил, үүргийн хуваарь гарган өгч, компанийн аппаратын үйл ажиллагаанд хяналт тавих, хуралд бэлтгэх, шийдвэрийн биелэлтийг хангуулах, судалгаа, дүгнэлт гаргах зэрэг үр нөлөө бүхий арга хэлбэрийг ашиглаж ажиллана.”

2.2 Компанийн гүйцэтгэх захирал, санхүүгийн ажилтнуудад өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 61.9 хувьтай байна.

“Урсгал-Ус ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар Урсгал-Ус ХХК-ийн гүйцэтгэх захиралд 9, ерөнхий нягтлан бодогчид 3 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бол 2 нь хэрэгжээгүй, 8 нь хэрэгжих шатандаа буюу дутуу хэрэгжсэн байна.

Компанийн гүйцэтгэх захиралд өгсөн дараах 2 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна. Үүнд:

- Компанийн стратеги төлөвлөгөө болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, мөрдөж ажиллах.
- Компанийн эзэмшилд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг актлах, худалдах, шилжүүлэхдээ холбогдох хууль, журмыг мөрдөх.

Мөн компанийн гүйцэтгэх захиралд өгсөн дараах 2 зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна. Үүнд:

- Дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, хяналт шалгалтын мөрөөр ажлын төлөвлөгөө гаргаж гүйцэтгэлийг тайлагнаж байх.
- Компанийн лабораторийг холбогдох стандартын дагуу магадлан итгэмжлэлтэй болгох.

Компанийн гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогчид өгсөн дараах 8 зөвлөмж 20-95 хувийн гүйцэтгэлтэй, хэрэгжих шатандаа байна. Үүнд:

Гүйцэтгэх захиралд өгсөн:

Зөвлөмж	Хэрэгжилт %	Хэрэгжилтийн байдал
1986 онд тогтоолгосон ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг өнөөгийн хууль тогтоомжуудтай нийцэж байгаа эсэхэд судалгаа хийх, бүс тогтоогоогүй барилга, байгууламжуудад хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоолгох арга хэмжээ авах.	20	Урсгал-Ус ХХК-ийн бүртгэлд байдаг 20-иод худаг, 1400 усан сан, цэнхэрийн бохир ус шахах барилга байгууламжид бүс тогтоолгохоос 4-р багийн нутаг дэвсгэрт байрлах бохир усны шахах станцын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоолгохоор аймгийн ГХБХБГ-т 17.09.13-ны 404 дугаар албан бичгээр хандсан байна.
Хугацаандаа төлөгдөөгүй авлагуудыг хуулийн байгууллагад шилжүүлэх, усны авлагыг барагдуулах бусад үр дүнтэй аргуудыг судалж, хэрэгжүүлэх.	50	Дорвитой, үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд борлуулалтын алба нь өр, авлагыг бууруулах график гарган мөрдөх, үйлчилгээний төлбөрөө төлөөгүй айл өрх, аж ахуйн нэгжүүдийг шүүхэд өгөх гэсэн 2 ажил тусгасан ч 22 айл өрхийн 6,099.4 шүүхэд өгч, 8 мэдэгдэх хуудас өгч 4209.7 мянган төгрөгийг барагдуулснаас өөр ажил хийгдээгүй байна. Айл өрхөөс авах 1-ээс дээш жил болсон, 200.0 мянган төгрөгөөс дээш төлбөртэй 84 өрхийн 26,277.8 мянган төгрөгийн, бусад байгууллагаас авах 1,096,644.8 мянган төгрөгийн авлага байна. Байгууллагаас авах авлагын судалгааг Хавсралт 1-д харуулав. Аудитын явцад усны борлуулалтын хуримтлагдсан авлагыг бууруулах үйл ажиллагааг жигдрүүлж, удирдлагын зүгээс тухай бүр хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэн “Борлуулалтын албаны 2017 оны ажлын төлөвлөгөө”-г батлууллаа.

Эдийн засгийн үр ашгийн тооцоог бодитой тооцоолсны үндсэн дээр санхүүгийн төлөвлөгөөг батлуулах, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж байх.	90	Аймгийн Засаг даргатай байгуулсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийх ажлын зардлыг тооцсон ч 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр хуралдсан ТУЗ-ийн хурлын материалд үйл ажиллагааны зардлыг тооцоолоогүй, үндсэн хөрөнгө худалдан авах зардлыг бусад зардлаас салгаж батлуулаагүй байна. Тайлант хугацаанд 11,592.0 мянган төгрөгийн харуулын сууц, тавилга, компьютер худалдан авсан байна.
Цэвэр, бохир усны шугам хоолойн тоо хэмжээ, чанар байдлыг нарийвчлан гаргаж хөрөнгийн мэдээллийг тодорхой болгох.	95	Тус компанийн бүртгэлд байгаа 6,633,010.0 мянган төгрөгийн шугам хоолойн тоо хэмжээ, насжилтийг нарийвчлан гаргасан ч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Хавсралт 2.
Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж байх.	95	Тайлант хугацаанд 10.0 саяас дээш үнийн бүхий шатахуун, экскаватор засвар, харуул хамгаалалтын албыг сонгон шалгаруулах ажилд ажлын хэсэг томилж, хурлын тэмдэглэл хөтөлсөн байна. Гэвч ажлын хэсгээс гүйцэтгэх захиралд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлэх, сонгосон байгууллагуудынхаа талаарх мэдээллийг баримтжуулан авч, үнэлж дүгнэх зэрэг ажил хангалтгүй байна.

Ерөнхий нягтлан бодогчид өгсөн:

Зөвлөмж	Хэрэг жилт %	Хэрэгжилтийн байдал
Санхүүгийн тайлан гаргах болон бусад шаардлагатай үед өр, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх, бодит бус өглөг, авлагыг бүртгэлд тусгадаг байдлыг таслан зогсоох.	33	Бүх харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, өглөг, авлагын журналын тохируулах бичилтийг хийхгүй байгаагаас хасах үлдэгдэл илэрхийлж нийт дүнг бууруулж тайлагнадаг байдал арилаагүй байна.

Бэлэн мөнгөөр хийгдэж байгаа дараа тайлангийн тооцоог холбогдох заавар, маягтын дагуу гаргаж, шаардлагатай анхан шатны баримтыг бүрдүүлж байх.

80

2017 оны 05 дугаар сараас эхлэн кассын тайланд зарлагын баримтыг хавсаргаж эхэлсэн ч мөнгөн урьдчилгааны тайланг хийж хэвшээгүй байна. Цаашид бэлэн мөнгөөр хийх ажил гүйлгээг багасгах шаардлагатай бөгөөд энэ нь их хэмжээний тодорхойгүй авлага үүсэх, төрийн өмчийн хөрөнгө дотоод хяналтгүй зарцуулагдах зэрэг эрсдэлийг бууруулах ач холбогдолтой байна. 2017 оны 3-р улирлын байдлаар нийт 201,408.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг бэлнээр хийсэн байна.

Бараа материалын хөдөлгөөнийг аккрузл сууриар хөтөлж, тайлант үеийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг, зардлыг бодитой тайлагнаж байх.

80

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч ажиллагсадтай болон байгууллагуудаас авах авлагыг бүрэн цэгцлээгүй, материалыг нь аваад зарцуулсан ч баримт материал нь ирээгүй учраас хаагдаагүй гэсэн тайлбартай авлага байсаар байна. Мөн тайлан журналууд нь хасах утгатай илэрхийлэгдэж нийт дүнг бууруулж илэхийлдэг, хоорондын тооцоогоор хаасан 2,431.1 мянган төгрөгийн хоолны зардлыг бүртгэлд бүрэн тусгаагүй, 3,500.0 мянган төгрөгийн байгаль орчны үнэлгээ хийлгэсэн материалыг шууд зардлаар бүртгэсэн зэрэг алдаа зөрчил оршсоор байна.

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж холбогдох мэргэжилтнүүдэд хариуцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүйгээс 29.9 хувийг хэрэгжүүлээгүй байна.
2. Тавигдсан актын 71.0 хувийг барагдуулсан байна.
3. Албан шаардлагын биелэлтийг 71.6 хувьтай хангаж ажилласан бөгөөд хандив олгох, авто машины эзэмшлийг шилжүүлэх, өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан бодитой болгох, ажиллагсадтай холбоотой тооцоог цэгцлэх зэрэг зөрчлийг арилгаагүй байна.
4. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгахаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ч өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж бүрэн

баталгаажуулаагүй, ажиллагсадтай холбоотой тооцоог хааж дуусгаагүй, хандив олгосон зэрэг зөрчил арилаагүй байна.

5. Аймгийн Засаг дарга, Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүдэд өгөгдсөн зөвлөмж 75.7 хувьтай хэрэгжсэн байна.
6. Компанийн гүйцэтгэх захирал, санхүүгийн ажилтнуудад өгсөн зөвлөмжийг 61.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

1. Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй гүйцэтгэх захирал А.Алтансүхэд сахилгын шийтгэл ногдуулж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авах.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд:

1. Тус компанийн дүрэм болон аймгийн ИТХ-ын 2013 оны 130 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Урсгал-Ус ХХК-ийн гүйцэтгэх захирал А.Алтансүхэд:

1. Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.
2. Санхүүгийн болон борлуулалтын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин, үүссэн асуудлыг хэлэлцэж тухай бүр шийдвэрлэх замаар хуримтлагдсан өр, авлага бууруулах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах зэрэг ажлыг үр дүнтэй болгох.

Холбогдох байгууллагын санал

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 213 дугаар албан бичгээр тус аудитын тайлангийн төслийг хүргүүлсэн бөгөөд Урсгал-Ус ХХК-ийн 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 564 дугаар албан бичгээр аудитын мөрөөр хийсэн ажлын тайлан, борлуулалтын албаны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан зэргийг ирүүлэв.

Аудитын мөрөөр хийсэн ажлыг үндэслэн давтан аудитын тайланд дараах өөрчлөлтийг орууллаа. Үүнд:

1. Тус компанийн захиралд өгсөн “Хугацаандаа төлөгдөөгүй авлагуудыг хуулийн байгууллагад шилжүүлэх, усны авлагыг барагдуулах бусад үр дүнтэй аргуудыг судалж хэрэгжүүлэх” гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 30 хувиар тооцсон байсныг “Аудитын явцад усны борлуулалтын хуримтлагдсан авлагыг бууруулах үйл ажиллагааг жигдрүүлж, удирдлагын зүгээс тухай бүр хяналт

тавих нөхцөлийг бүрдүүлэн Борлуулалтын албаны 2017 оны ажлын төлөвлөгөөг батлууллаа” гэсэн тодруулга нэмж хэрэгжилтийг 50 хувь болгон өөрчлөлт оруулав.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ